

**Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны  
08 дугаар сард хийсэн ажлын товч мэдээ**

2023 оны 8 дугаар сарын 24

Дархан-Уул аймаг

Тус алба 5 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж, хяналт шалгалт хийхэд хүний нөөцийн дутагдалтай ажиллаж байна. Дотоод аудиторын сул 2 орон тоог нөхөх тусгай шалгалтад тэнцсэн 1 иргэний нэр дэвшүүлэх тогтоол Төрийн албаны зөвлөлийн Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөлөөс ирсэнийг АТГ-т ХАСУМ-ыг хянуулахаар хүргүүлсэн. Дотоод аудиторын 1 сул орон тоо байгаа талаар байгууллагын цахим хуудас, фэйсбүүк хуудаст тус тус олон нийтэд мэдээлж байна.

Аймгийн Засаг даргын баталсан 23-06-23-02/12 дугаар удирдамжийн дагуу Соёл урлагийн газрын үйл ажиллагаанд дотоод аудит хийж 2 зөвлөмж, илэрсэн зөрчлийн арилгуулах, давтан гаргахгүй байх Улсын ахлах байцаагчийн 1 албан шаардлага хүргүүллээ.

Аймгийн Засаг даргын баталсан 23-06-23-02/14 дугаар удирдамжийн дагуу Төв номын сангийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж нягтлан бодогч, ахлах номын санч нараас тайлбар, тодруулга авч байна.

Тус албаны 2023 оны 2-р улиралд гүйцэтгэсэн ажлын талаар дотоод аудитын хорооны хурлын материалыг боловсрууллаа.

Хугацаатай мэдээ тайланг холбогдох газарт нь хүргүүллээ. Үүнд:

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 7 дугаар сарын тайланг СТСХ-т цахимаар хүргүүлсэн.

- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2023 оны 2 дугаар улирлын дотоод аудитыг хийж гүйцэтгэн аймгийн Засаг дарга болон Сангийн яамны СХЭУГ-т хүргүүллээ.

- Төрийн албаны зөвлөлийн Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөлөөс төрийн албан хаагчтай холбоотой ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг албан бичгээр тус газарт хүргүүлсэн.

Албаны дарга удирдах ажилтаны хуралд оролцож, аймгаас өгсөн цаг үеийн мэдээллийн талаар албан хаагчдад мэдээлэл өглөө.

Албан хаагчид дараах сургалтад хамрагдлаа. Үүнд:

- Цахим хөгжил харилцаа холбооны яамнаас зохион байгуулсан “Цахим аймаг” бодлогын зөвлөмж сургалтад 2 албан хаагч оролцон судалгааны үнэлгээ өгсөн.

- Аймгийн ИТХ-аар батлагдсан “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөр”-ийн хүрээнд Аймгийн ЗДТГ, Хөгжлийн шийдэл ТББ-тай

хамтран зохион байгуулсан “Ил тод байдлыг нэмэгдүүлэх, авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтад 2 албан хаагч

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА**